


Уншигч судлаач та бүхэндээ зориулж “Тогтмол хэвлэлийн сан хөмрөгт” буй Орос сэтгүүлийг цувралаар толилуулж байна.





Аполлонь

1909-1917 оны хооронд Оросын Санкт-Петербург хотод хэвлэгдэж байсан Оросын дүрслэх урлаг, театр, хөгжим, уран зохиолын чиглэлээр нийтлэл бичдэг сэтгүүл. Эхний дугаар нь жүжигчин Георгий Лукомскогод зориулагдан гарч байжээ.

Тус сэтгүүл тогтмол хэвлэлийн сан хөмрөгт 1909-1917 он хүртэл хадгалагдаж байна.

Архивное дело


Архивын түүх, онол, архитектур, бүртгэлийн менежментийн асуудлаарх Зөвлөлтийн шинжлэх ухаан, практик сэтгүүл. 1923-1941 онд "Архивное дело", 1956 оноос "Информационный бюллетень Главного архивного управления МВД СССР", 1965 оноос "Вопросы архивоведения" нэрээр гарч байв. Өдгөө "Отечественные архивы" нэрээр гардаг сэтгүүл. 1925, 1935-1941 оны дугаарууд



Архив биологических наук

1892 оноос Санкт Петербург хотноо хэвлэгдэн гарч эхэлжээ. Эзэн хааны Академиас орос франц хэлээр хэвлэн гаргаж байв. Сэтгүүлийн ерөнхий редактороор алдарт микробиологич С.Н.Виноградский ажиллаж байв.



1929-1939, 1941 оны дугаарууд



Аграрные проблемы 1927-1935 онд хэвлэгдэн гарч байсан сэтгүүл. 1931-1935 оны дугаарууд

Астрономический журнал

1924 оноос гарч байгаа одон орны судлалын сэтгүүл. Энэхүү сэтгүүл нь одон орон судлал, нарны физик, гаригийн астрофизик, радио одон орон, одон орны аргууд, багаж хэрэгсэл зэргийн талаарх нийтлэлийг хэвлэдэг. Мөн түүнчлэн энэ чиглэлийн ном товхимол, олон улсын хурлын мэдээ, шүүмжийг нийтэлдэг. 1932, 1934-1995 он хүртэлх дугаарууд




Архитектура СССР

1933-1992 онд ЗХУ-ын Архитекторуудын холбооноос эрхлэн гаргаж байсан сар тутмын сэтгүүл. Барилга, архитектур, хотын хөгжлийн асуудлыг хөндөж байсан уг сэтгүүл нь дайны жилүүдэд тогтмол гараагүй. Харин 1951 оны 11-р сараас эхлэн сар бүр гарах болжээ. 1938-1940, 1944, 1947, 1951, 1953-1961, 1963-1991, 1999 оны дугаарууд

Авто тракторное дело

1928 оноос гарч эхэлсэн сар тутмын сэтгүүл. 1930 онд Автомашины тракторын судалгаа, хөгжлийн институтийг зохион байгуулж, машин, тракторын үйлдвэрлэлийг хөгжүүлэх шинэ загвар, технологийг бий болгох, техникийн шинэ шийдлийг гаргах ажлыг сайжруулахүүднээс тусгай сэтгүүл гаргах шаардлагатай болсон. Ингээд “Авто тракторное дело” нэрээр сар бүр гарах болжээ.

1938-1939 он хүртэлх дугаарууд



Архив анатомии, гистологии и эмбриологии



1916 оноос эхлэн хэвлэгдэн гарсан Оросын морфологийн шинжлэх ухааны нэр хүндтэй сэтгүүл. Үүсгэн байгуулагч нь Оросын Шинжлэх ухааны Академи юм.

1939, 1953-1955, 1957-1975, 1991 он хүртэлх дугаарууд

Автоматика и телемеханика

1930-аад онд автомат хяналтын онол, технологийн салбарын судалгааны түвшин сул, судалгааны баг хамтлагууд харилцан хамаарал багатай байсан бөгөөд тэднийг нэгтгэх нь Техникийн Инженерүүдийн хамтын ажиллагааны Академийн гол зорилго байв. 1935 онд академич А.А. Чернышевын хүчин зүтгэлээр Бүх Холбоотын автоматик, телемеханикийн чиглэлийн бага хурлыг зохион байгуулж чадсан бөгөөд тус хурлын нэг гол үр дүн болж энэ сэтгүүл мэндэлжээ. 1936 онд анхны дугаар нь хэвлэгджээ.

1939, 1949, 1955-1959, 1962-1965, 1967-1973, 1977, 1980-1992 он хүртэлх дугаарууд



Архив патологической анатомии и патологической физиологии

Зөвлөлтийн эмгэг судлалын судалгааны дийлэнх үр дүнг хэвлэн гаргасан гол хэвлэл. 1935 оноос “Архив патологической анатомии и патологической физиологии” нэрээр гарч байгаад “Архив патологии”, “Патологическая анатомия” гэх зэргээрнэр нь өөрчлөгдсөн.

1939, 1941 оны дугаарууд

